

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/38/ НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Гантулга

Утас: 70432545

цахим хаяг: gantulga.ts @audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / төгрөгөөр/.....	5
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
4. Аудитын илрүүлэлт.....	9
4.1 Залруулсан алдаа.....	9
4.3 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
ХНХ	<i>Хөдөлмөр нийгмийн хамгаалал</i>
ЭХМК	<i>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс</i>
ХХҮГ	<i>Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар</i>



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ
ТАНАА

2022.02.14 № 2/31
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>545166.40</u>	<u>0.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	545166.40	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	545166.40	0.00
3121	Төгрөг	545166.40	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	545166.40	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>545166.40</u>	<u>0.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>24000.00</u>	<u>24000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24000.00	24000.00
413	Өглөг	24000.00	24000.00
4136	Бусад өглөг	24000.00	24000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	24000.00	24000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>521166.40</u>	<u>-24000.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	521166.40	-24000.00
512	Хуримтлагдсан үр дүн	521166.40	-24000.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1368000.41	521166.40
51220	Тайлант үеийн үр дүн	-846834.01	-545166.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>545166.40</u>	<u>0.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13683305929.28	5,758,604,427.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6980629.28	57427.31
120	Нийтлэг татварын бус орлого	6980629.28	57427.31
120002	Хүүгийн орлого	6980629.28	57427.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13676325300.00	5,758,547,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13521444400.00	5603564000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13521444400.00	5603564000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	154880900.00	154983000.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	154880900.00	154983000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13684152763.29	5759149593.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13684152763.29	5759149593.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13684152763.29	5759149593.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	13499499118.00	5680992243.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13499499118.00	5680992243.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	135703578.12	57757350.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	135703578.12	57757350.71
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	48950067.17	20400000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	48950067.17	20400000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-846834.01	-545166.40
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-846834.01	-545166.40

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,368,000.41	1,368,000.41
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,368,000.41	1,368,000.41
C07	Тайлант үеийн үр дүн			-846,834.01	-846,834.01
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	521,166.40	521,166.40
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	521,166.40	521,166.40
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	521,166.40	521,166.40
D08	Тайлант үеийн үр дүн			-545,166.40	-545,166.40
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-24,000.00	-24,000.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	13,709,431,471.28	5,769,668,280.31

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,106,171.28	11,121,280.31
120	Нийтлэг татварын бус орлого	33,106,171.28	11,121,280.31
120002	Хүүгийн орлого	6,980,629.28	57,427.31
120009	Бусад орлого	26,125,542.00	11,063,853.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	13,676,325,300.00	5,758,547,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,521,444,400.00	5,603,564,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,521,444,400.00	5,603,564,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	154,880,900.00	154,983,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	154,880,900.00	154,983,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	13,708,886,305.29	5,770,213,446.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,708,886,305.29	5,770,213,446.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,708,886,305.29	5,770,213,446.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,524,232,660.00	5,692,056,096.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13,524,232,660.00	5,692,056,096.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	184,653,645.29	78,157,350.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,653,645.29	78,157,350.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	545,165.99	(545,166.40)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	545,165.99	(545,166.40)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.41	545,166.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	545166.4
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5758547000,00	5,749,843,446.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5758547000,00	5,749,843,446.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	575854700,00	5,749,843,446.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	5758547000,00	5,749,843,446.71
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	5,749,843,446.71

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,758,547,000.00	5,749,268,280.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,603,564,000.00	5,603,564,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,603,564,000.00	5,603,564,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	154,983,000.00	134,583,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	154,983,000.00	134,583,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	11,121,280.31
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих /хүүгийн орлого/		57,427.31
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих /буцаасан орлого/		11,063,853.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		545166.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халамжийг сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд ахмадуудын амралт, рашаан сувиллын эрхийн бичиг, зорилтот бүлгийн гэрийн асрамж халамжийн үйлчилгээтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2022 оны 02 дүгээр сарын 07-ноос 2021 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24 -ний өдрийн 43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Халамжийн сан нь “Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот өрх, иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллахад оршино.” гэж тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

- *Нийгмийн халамжийн тэтгэвэр*
- *Нийгмийн халамжийн тэтгэмж*
- *Нийгмийн халамжийн үйлчилгээ*
- *Нийгмийн хөгжлийн үйлчилгээ*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Нийгмийн халамжийн багц хуулиудын өөрчлөлт*
- *Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын өөрчлөлт*

Засгийн газрын 2018 оны 31 дүгээр тогтоолын өөрчлөлт

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халамжийн сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2021 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна.

Харин ХХҮГ-ын захиргаа хяналтын хэлтэс дотоод хяналтаа хэрэгжүүлсэн хэдий ч Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан ХХҮЕГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн тушаалаар батлагдсан А/58 тоот аргачлалын дагуу үзүүлэх “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-ний үр дүн бага түүнд хариуцсан хэлтсийн зүгээс тавих хяналт хангалтгүй газрын дотоодын хяналт сул байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 5758.5 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 57.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 46.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тайлант оны эхэнд 545,166.40 төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд болон эцэст авлагагүй үлдэгдэлгүй байна.

Тайлант оны эхэнд 24.0 мянган төгрөгийн өр төлбөртэй байсан бол өөрчлөлт ороогүй үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 521.2 мянган төгрөг байсан ба оны эцэст 24.0 мянган төгрөг болж тайлант онд 545.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Халамжийн сангийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,758,547.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,758,547.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 5,758,547.0 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр нийт 5,749,813.4 мянган төгрөгийн санхүүжилт авснаас улсын төсвөөс 5,603,564.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 134,583.0 мянган төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд зарцуулж, арилжааны банкны хүүгийн орлогод 57.4 мянган төгрөг, тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт, тусламжийн буцаасан орлого болох 11,063.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Халамжийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,939,763.2 мянган төгрөгөөр буюу 42 хувиар буурсан нь халамжийн сангийн зарим үйлчилгээ олголтууд И- халамж цахим программаар дамжин Сангийн яамнаас иргэдийн дансанд шууд хөрвүүлдэгтэй холбоотой байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын үйл ажиллагаанд тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 706.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийг хугацаандаа оруулсан хоцроосон мэдээлэл байхгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын 24 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 635.6 мянган төгрөгийн төлбөрийн актыг төсөвт бүрэн барагдуулж, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ болон ахмад настуудад үзүүлж байгаа өдрийн болон явуулын үйлчилгээнүүдийг анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3260.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 570.0 мянган төгрөгийн төлбөрийн акт 1, эрх зүйн актын хувьд нэг заалттай боловч үзүүлэх үйлчилгээний чиглэлээр өөр үйлчилгээнд 2690.0 төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Залруулга хийгдсэн хийгдсэн ажил гүйлгээ байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Их Алтай Тогтвортой хөгжил ТББ-нь “Зорилтот бүлгийн иргэдэд ковидын үед хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар авах боломж, хэрэглээг нэмэгдүүлэх” сэдэвт сургалтыг танхимаар 180 иргэнийн ирцтэйгээр 5 өдөр зохион байгуулсан гэх боловч сургалтад хамрагдсан иргэдийн дунд 71- 91 насны 19 настнаас гадна, сургалтад тодорхой хамрагдаагүй хүмүүсийн бүртгэлтэй, сургалтын материалаар архивын нэгж үүсгээгүй, олон жилийн давтамжтай нэг ТББ дангаараа үйлчилгээ үзүүлэх нь нэг талаас сургалт чанаргүй, нөгөөтэйгөөр давуу байдал бий болгосон байдал ажиглагдаж байна. Аудитын явцад энэ талаар тодруулахад ТББ-ын тэргүүн интернэтээс ковидтой холбоотой бэлэн материалыг хэвлэн ирүүлсэн, сургалтын процесст газрын холбогдох хэлтэс, дотоод хяналтын баг бүрэн хяналт тавиагүйгээс тухайн ТББ сургалтын гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэнтэй холбоотой 570.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, ХХҮГазрын даргын 2020 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн А/58 тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-ын холбогдох заалт, 4 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн хуулийн заалт, Аудитын олон улсын стандартын -300, “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Ахмадуудын рашаан сувиллын эрхийн бичиг, гэрийн асрамж халамжийн үйлчилгээтэй холбоотой асуудал.

4.3.1 Илрүүлэлт: ХХҮГ-нь тайлант хугацаанд 461 ахмад настанд амралт сувиллын үйлчилгээ үзүүлсэн байна. Дээрх амрагчдын амралтын эрхийн бичгийг харилцагч амралтын газар, сувиллын газруудтай тооцоо нийлэн баталгаажуулаагүй, Төгөл, Шегиртэй, ЭМЖЖ, Өнөр БСОБ сувиллын газруудын 1800.0 мянган төгрөгийн 6 эрхийн бичгийг дутагдуулсан, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний унааны зардал 890.0 мянган төгрөгийг шаардлага хангахгүй тооцооны хуудсаар олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж ХХҮГазрын даргын 2020 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн А/58 тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-ын холбогдох заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	Халамжийн сан	2	3260.0			1	570.0			1	2690.0

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР